

*Монгол Улсын Их Сургуулийн 60 жилийн ойд зориулав.*

## ОРШИЛ БИЧИХИЙН УЧИР

2001 оны эхээр МУИС-ийн дэргэд **Монгол Судлалын Төв** (МСТ) албан ёсоор байгуулагдсан билээ. МСТ нь монгол судлалын судлагаа, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг эрхилэн хөгжүүлэх зорилготой бөгөөд МУИС-ийн бүрэлдэхүүний эрдэм шинжилгээ-сургалтын нэгж мөн болно.

МСТ нь монгол хэлбичиг, түүх, нийгэм, эдийн засаг, хуульзүй, байгалийн ухааны салбарт МУИС-ийн хэмжээнд гүйцэтгэж байгаа монгол судлалын эрдэм шинжилгээ, сургалт-судлагааны ажлыг уялдуулан зохицуулах үндсэн дээр эрдэмтэн багш нарын хүчийг нэгтгэн төвлөрүүлж гадаад харилцааг хөгжүүлэх, монгол болон гадаадын мэдэлгэ чадвартай монголчидыг бэлтгэх, тэдний ажиллах таатай орчин бүрдүүлэхийг ажлын гол чиглэлээ болгоно.

МСТ нь эрдэм шинжилгээний жил тутмын сэтгүүл - АСТА *MONGOLICA*, монголч эрдэмтдийн шинэ бүтээлийг хэвлэн нийтлэдэг *SERIES MONOGRAPHICA MONGOLICA* хэмээх цуврал, олон нийтийн хүртээл болж хараахан чадаагүй дурсгалын эхбичигийн судлагааг нийтлэдэг *MONUMENTA MONGOLICA* хэмээх дурсгалт бичигийн чуулган болон мэдээллийн хэвлэлтэй байх болно.

Одоо МУИС-ийн МСТ-д Германы монголч эрдэмтэн Удо Баркманн (Udo Barkmann) профессор урилгаар ирж эрдэм шинжилгээ сургалтын ажилд идэвхитэй оролцож байна.

Өнгөрсөн нэгэн жилийн хугацаанд эдийн засаг санхүүгийн хувьд хязгаар саад байсан боловч МСТ үйл ажиллагааныхаа хүрээнд 2001 онд БНСУ-ын Монгол судлалын нийгэмлиг (The Korean Association for Mongol Studies), Солонгосын Өргөн нэвтрүүлгийн нийгэмлиг (The Korean Association of Broadcasting Studies)-тэй хамтран Улаанбаатар хотноо Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж<sup>1</sup>, манай эрдэмтэд 2001 онд Японы Монгол судлалын нийгэмлиг (Japanese Association for Mongolian Studies)-ийн Эрдэм шинжилгээний хаварын хурал, 2002 онд Солонгосын Монгол судлалын нийгэмлигийн эрдэм шинжилгээний ээлжит XV хуралд тус тус оролцлоо.

---

<sup>1</sup> *The 14th International Conference KOREA and MONGOLIA*, July 23. 2001, Ulaanbaatar, pp. 225.

Дурдсан хугацаанд МСТ-өөс SERIES MONOGRAPHICA MONGOLICA цувралын анхны ботийг нийтлүүлж<sup>2</sup> MONUMENTA MONGOLICA хэмээх дурсгалт бичигийн чуулганы эхний хоёр дугаараар "Асрагч нэртийн түүх"-ийн эхбичигийн судлагаа, "Хураангуй Алтан товч"-ийн эх бичигийн судлагаа-г тус тус нийтлүүлэхээр завдаж байна.

Энэхүү толилуулан буй боть бол МСТ-ийн АСТА MONGOLICA хэмээх эрдэм шинжилгээний сэтгүүлийн анхны дугаар бөгөөд үүнд монголын судлалын уламжлалт салбарын бүтээл зонхилон орсон боловч цааш цаашдын дугаарт монголын судлалд холбогдох нийгэм, байгалийн ухааны бүх салбарын эрдэм шинжилгээний өгүүлэлийг хамарч, Монгол болон гадаадын монголч эрдэмтдийн хувьд энэ сэтгүүл ямагт нээлттэй байх болно.

Чой. Лувсанжав профессортан 31 жилийн өмнө хэлшинжлэлийн докторын зэрэг хамгаалсан бүтээлдээ монгол хэлний хэлбэрсудлалын асуудлыг түрүү түрүүчийн хэвшил болсон загвараас өөрөөр, монгол хэлний дотоод онцлогийнхи нь үүднээс авч үзсэн бөгөөд тэрхүү өвөрмөц байдлыг англи хэлтэй зэргэцүүлэн гаргасан билээ. Зүй нь, эл судлагаа нийтийн хүртээл болох ёстой байсан боловч цаг нөхцөл бүрдээгүйн учир одоо болтол хэвлэгдэн гарч чадсангүй тул энэ удаа уг бүтээлийн хураангуйг толилуулахаар оруулсан болно.

АСТА MONGOLICA сэтгүүлд монгол болон гадаадын монголч нарын судлагааны шинэ сэрэг үр дүн бүхий өгүүлэл, ахмад эрдэмтдийн хэвлүүлж завдаагүй шилдэг бүтээлийг англи, орос, франц, герман зэрэг хэлээр нийтлэж байх тул энэ сэтгүүл дэлхийн монголын судлалд зохих хувь нэмэрээ оруулна гэж гүнээ найдаж байна.

МСТ-ийн Эрдэмтэн нарийн бичигийн дарга

*Цэвэлмийн Шагдарсүрэн*

2002 оны 4-р сарын 10  
Улаанбаатар хот.

---

<sup>2</sup> Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын үсэг бичигийн товчоон*, Улаанбаатар, 2001, 300 тал.